

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 4 дүгээр сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлт дараах байдалтай байна.

Үүнд :

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	/тоогоор/			
		2010-III	Нэмэгдсэн	Хасагдсан	2010-IV
1	Даатгалын компани	17	0	1	16
2	Даатгалын компанийн салбар	132	0	0	132
3	Даатгалын төлөөлөгч	1705	202	33	1874
4	Даатгалын зуучлагч	6	1	0	7
5	Даатгалын хохирол үнэлэгч	3	2	0	5
6	Актуарч	10	0	0	10
7	Аудитын компани	20	0	0	20
8	Аудитор	46	0	0	46
9	Бусад өөрчлөлт : хувь нийлүүлэгч /1/			1	

2010 оны 4 дүгээр сард даатгалын компанийн салбар, актуарч, аудитын компани болон аудиторуудын тоонд ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Хорооны 2010 оны 4 дүгээр сарын хуралдаанаар “Соёмбо инк даатгал” ХХК нь “Түшиг даатгал” ХХК-тай нэгдэж байгаатай холбоотойгоор даатгалын компанийн тоо 1-ээр буурсан.

Харин даатгалын төлөөлөгчийн хувьд “Бодь даатгал” ХХК /101/, “Монголтраст холдинг даатгал” ХХК /2/, “Практикал даатгал” ХХК /16/, “Прайм даатгал” ХХК /83/-ийн нийт 202 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Бодь даатгал” ХХК-ийн 33 төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор даатгалын төлөөлөгчийн тоо 1874 болсон байна.

Мөн энэ сард “Ренессанс” ХХК-д даатгалын зуучлагчийн, “Файн эстимэйт” ХХК болон “Гэрэгэ эстимэйт” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

“Түшиг даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж дүрмийн сангийн 10 хувийг “Зоос банк” эзэмшдэг байсныг М.Жалавдоржид шилжүүлсэн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 4 дүгээр сарын байдлаар харуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-I	2010-II	2010-III	2010-IV
1	Даатгалын нийт хураамж	910 215,8	1 399 842,7	2 584 022,9	3 790 544,8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	404 565,6	345 313,2	899 945,5	551 294,3
3	Давхар даатгалд төлсөн хураамж	53 027,2	150 552,1	240 750,1	910 581,9
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	5 787,0	3 872,0	7 585,0	17 304,0
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	200 000 000,0	49 097 880,0	6 268 000,0	180 394 500,0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	37 513,7	37 145,0	227 184,0	52 292 580,0

Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Эм Си Эс Кока кола” ХХК-ийн бараа материалын үлдэгдлийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт 52,3 сая төгрөг олгосон байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа, сая төгрөгөөр



Даатгалын компаниудын 4 дүгээр сард төвлөрүүлсэн даатгалын хураамжийн орлого 3 дугаар сарынхаас 46,7 хувиар өссөн хэдий ч нөхөн төлбөр 38,7 хувиар буурсан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-I	2010-II	2010-III	2010-IV
1	Даатгалын нийт хураамж	2 570,7	40 929,4	2 957,6	8 674,1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	410,0	1 935,9	765,0	2 735,1
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	-	27 440,0	-
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11 гэрээ	9 гэрээ	6 гэрээ	5 гэрээ
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	6 гэрээ	4 гэрээ	3 гэрээ	5 гэрээ
	-Байгууллагын хугацаат даатгалд	1 гэрээ /177 хүн/	5 гэрээ /686 хүн/	3 гэрээ /255 хүн/	-
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	4 гэрээ /12 хүн/	-	-	-
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10 000,0	20 000,0	15 000,0	616 500,0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	360,0	400,0	400,0	500,0

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь 4 дүгээр сард “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээгээр 5 хүнийг даатгалд хамруулж 8,6 сая төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Тухайн сард өндөр хамгаалалттай эрүүл мэндийн даатгалын 9 тохиолдол, байгууллагын хугацаат амьдралын даатгалаар 1 хүн нас барсан, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 11 даатгалын тохиолдол гарч нөхөн төлбөрт нийт 2,7 сая төгрөг олгосон байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-III	2010-IV
1	Даатгагчид дамжуулан шилжүүлсэн даатгалын хураамж	15 865,7	103 228,2
2	Даатгалын зуучлагчийн орлого	7 435,1	30 997,9
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	29,00	50,00
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	2 954 787,5	3 567 401,6

2010 оны 4 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 3,6 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 50 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучилж 30,9 сая төгрөгийн зуучлалын орлого олж даатгалын зуучлалын орлого 3 дугаар сарынхаас 4,2 дахин нэмэгдсэн нь даатгалын зуучлагчдын үйл ажиллагаа идэвхжиж байгааг харуулж байна.

Даатгалын зуучлагчийн орлогын 44,7 хувийг “Скай эрдэнэ” ХХК, 26,2 хувийг “Лоялти солюшн” ХХК, 19,4 хувийг “Асимон брокерс” ХХК, 9,8 хувийг “Ачит ундарга” ХХК төвлөрүүлж ажилласан бол “Эм Жи Ай Би” ХХК болон “Аме” ХХК нь даатгалын зуучлалын орлого олоогүй байна.

2010.05.12